



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хутаг-Өндөр сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/131/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2022 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас:70342580 Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn Ахлах аудитор: П.Мөнхтуяа Утас: 70342716 Цахим хаяг: MonkhtuyaP@audit.gov.mn Аудитор: Утас: 70342716 Цахим хаяг:</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4-15
3. Аудитын тайлан.....	15-18
3.1 Ерөнхий зүйл.....	
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	
3.4 Материаллаг байдал.....	
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	
3.8 Аудитын гол асуудал.....	
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	
4. Аудитын илрүүлэлт.....	18-20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМДС	Эрүүл мэндийг дэмжих сан
ОНТС	Орон нутгийн төсвөөс санхүүжих



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

᠘᠐᠔᠔-᠐᠔-᠔5 № 111

тантай _____ ны № _____ т

ХУТАГ-ӨНДӨР СУМЫН ЭМТ-ИЙН
ДАРГА Б.ТУЯАЦЭЦЭГ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хутаг-Өндөр сумын ЭМТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хутаг-Өндөр сумын ЭМТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Д.АНХБАЯР

006020199

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>50,468,290.96</u>	<u>407,635,215.85</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	7,910,540.39
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	7,910,540.39
3121	Төгрөг	00.00	7,910,540.39
31211	Төрийн сангийн харилцах	00.00	3,343,877.50
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	00.00	4,566,662.89
33	АВЛАГА	47,457.68	239,352,719.77
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	47,457.68	1,721,919.77
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	237,630,800.00
35	БАРАА МАТЕРИАЛ	50,420,833.28	160,371,955.69
351	Түүхий эд материал	22,172,925.08	118,174,075.92
35110	Тусгай зориулалттай материал	00.00	2,599,450.00
35130	Эм боох материал	22,172,925.08	115,574,625.92
354	Хангамжийн материал	27,302,553.20	41,122,524.77
35410	Бичиг хэргийн материал	747,837.00	537,137.00
35420	Аж ахуйн материал	18,135,891.50	16,318,559.00
35440	Түлш, шатах тослох материал	4,400,000.00	6,391,188.00
35450	Барилгын засварын материал	00.00	122,100.00
35460	Хүнсний материал	4,018,824.70	6,396,291.85
35470	Бусад хангамжийн материал	00.00	11,357,248.92
35500	Биологийн хөрөнгө	945,355.00	1,075,355.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,571,807,906.07</u>	<u>1,617,988,882.53</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,571,807,906.07	1,617,988,882.53
391	Газар	33,566,000.00	33,566,000.00
392	Биет хөрөнгө	1,537,279,406.07	1,583,749,132.53
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,520,824,771.87	1,532,824,771.87
39202	Хуримтлагдсан элэгдэл	-242,524,837.38	-270,728,200.02
39203	Авто-тээврийн хэрэгсэл	147,884,434.00	145,724,434.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-24,532,234.86	-45,080,473.86
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	279,191,997.28	375,545,492.29
39206	Хуримтлагдсан элэгдэл	-158,952,489.94	-167,257,762.49
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34,569,598.22	34,569,598.22
39208	Хуримтлагдсан элэгдэл	-19,802,041.27	-22,700,268.91
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,145,000.00	1,560,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-524,791.85	-708,458.57
393	Биет бус хөрөнгө	962,500.00	673,750.00
39301	Програм хангамж	1,155,000.00	1,155,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-192,500.00	-481,250.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,622,276,197.03</u>	<u>2,025,624,098.38</u>

4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	630,885.00	12,909,813.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	630,885.00	12,909,813.00
413	Өглөг	630,885.00	12,909,813.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	580,153.00	00.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	12,609,813.00
4136	Бусад өглөг	50,732.00	300,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	50,732.00	300,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,621,645,312.03	2,012,714,285.38
51	Засгийн газрын хувь оролцоо	1,621,645,312.03	2,012,714,285.38
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	743,295,181.25	743,295,181.25
51101	Өмч: - төрийн	743,295,181.25	743,295,181.25
512	Хуримтлагдсан үр дүн	414,118,843.15	805,187,816.50
51210	Өмнөх үеийн үр дүн	414,118,843.15	414,118,843.15
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	391,068,973.35
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	464,231,287.63	464,231,287.63
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,622,276,197.03	2,025,624,098.38

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	906,559,221.56	2,031,903,751.72
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	83,144,315.56	744,882,990.72
120	Нийтлэг татварын бус орлого	83,144,315.56	744,882,990.72
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,014,647.00	237,630,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	237,630,800.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6,014,647.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	823,414,906.00	1,287,127,912.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	733,345,800.00	681,884,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	733,345,800.00	681,884,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,703,500.00	494,377,968.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	308,500.00	1,372,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,395,000.00	478,498,968.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	14,506,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	82,325,949.00

**Хутаг-Өндөр сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	82,325,949.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	66,365,606.00	28,432,444.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	66,365,606.00	28,432,444.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	877,880,520.05	1,640,226,365.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	877,880,520.05	1,640,226,365.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	868,349,646.38	1,539,076,365.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	544,200,815.79	651,938,858.11
210101	Үндсэн цалин	316,149,010.04	331,328,015.00
210102	Нэмэгдэл	172,483,698.15	264,620,149.11
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,181,000.00	9,432,000.00
210104	Урамшуулал	47,387,107.60	46,558,694.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,739,511.19	89,137,198.23
210201	Тэтгэврийн даатгал	50,102,911.19	61,678,467.75
210202	Тэтгэмжийн даатгал	5,409,200.00	8,569,966.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,327,300.00	5,186,585.47
210204	Ажилгүйдлийн даатгал	1,081,800.00	1,282,827.66
210205	Эрүүл мэндийн даатгал	10,818,300.00	12,419,350.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	74,416,248.00	78,845,249.00
210301	Гэрэл, цахилгаан	8,555,104.00	10,702,282.00
210302	Түлш, халаалт	62,235,944.00	64,341,367.00
210303	Цэвэр, бохир ус	3,625,200.00	3,801,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,125,390.00	32,203,426.08
210401	Бичиг хэрэг	1,677,800.00	3,506,915.00
210402	Тээвэр, шатахуун	17,465,900.00	21,130,240.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	312,990.00	1,781,417.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	754,200.00	5,662,090.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	914,500.00	122,763.58
2105	Нормативт зардал	84,025,338.84	586,867,275.72
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	72,754,758.24	556,159,512.87
210502	Хоол, хүнс	9,068,455.60	30,707,762.85
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,202,125.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,050,000.00	7,336,930.00
210604	Урсгал засвар	1,050,000.00	7,336,930.00
2107	Томилолт, зочны зардал	850,000.00	1,322,000.00
210702	Дотоод албан томилолт	850,000.00	1,322,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,269,960.00	10,196,091.68
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,234,096.00	8,993,816.68
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	99,000.00	450,000.00

Хутаг-Өндөр сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210803	Даатгалын үйлчилгээ	79,500.00	133,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,132.00	142,193.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	67,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,045,000.00	346,500.00
210807	Газрын төлбөр	81,382.00	62,632.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	630,850.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	65,672,382.56	81,229,336.55
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,369,434.00	1,846,868.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	61,302,948.56	79,382,468.55
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,530,873.67	101,150,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,679,000.00	101,150,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	52,200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,679,000.00	48,950,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,815,873.67	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,815,873.67	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,036,000.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>28,678,701.51</u>	<u>391,677,386.35</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,946,947.98	608,413.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	5,946,947.98	00.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	608,413.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-5,946,947.98	-608,413.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>22,731,753.53</u>	<u>391,068,973.35</u>

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>823,414,906.00</u>	<u>1,287,020,761.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>823,414,906.00</u>	<u>1,287,020,761.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	733,345,800.00	681,884,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	733,345,800.00	681,884,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,703,500.00	494,377,968.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	308,500.00	1,372,200.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,395,000.00	478,498,968.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	14,506,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	82,325,949.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	82,325,949.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	66,365,606.00	28,432,444.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	66,365,606.00	28,432,444.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	804,195,096.00	1,221,242,220.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	804,195,096.00	1,221,242,220.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	794,664,222.33	1,120,092,220.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	543,668,120.47	652,519,011.11
210101	Үндсэн цалин	315,616,314.72	331,908,168.00
210102	Нэмэгдэл	172,483,698.15	264,620,149.11
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,181,000.00	9,432,000.00
210104	Урамшуулал	47,387,107.60	46,558,694.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,739,511.19	90,859,118.00
210201	Тэтгэврийн даатгал	50,102,911.19	63,400,387.52
210202	Тэтгэмжийн даатгал	5,409,200.00	8,569,966.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,327,300.00	5,186,585.47
210204	Ажилгүйдлийн даатгал	1,081,800.00	1,282,827.66
210205	Эрүүл мэндийн даатгал	10,818,300.00	12,419,350.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	76,011,248.00	80,285,249.00
210301	Гэрэл, цахилгаан	7,751,336.00	10,702,282.00
210302	Түлш, халаалт	65,009,912.00	65,781,367.00
210303	Цэвэр, бохир ус	3,250,000.00	3,801,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,708,290.00	31,418,843.50
210401	Бичиг хэрэг	1,229,400.00	1,736,800.00
210402	Тээвэр, шатахуун	17,465,900.00	21,681,428.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	312,990.00	1,781,417.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	700,000.00	4,219,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00	1,999,798.00
2105	Нормативт зардал	69,162,190.67	234,737,748.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	54,183,190.67	200,823,248.00
210502	Хоол, хүнс	11,223,000.00	32,354,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,756,000.00	1,560,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,503,105.00	13,151,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	357,905.00	00.00

210604	Урсгал засвар	1,145,200.00	13,151,100.00
2107	Томилолт, зочны зардал	850,000.00	1,322,000.00
210702	Дотоод албан томилолт	850,000.00	1,322,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,288,378.00	10,199,366.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,234,096.00	8,946,359.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	99,000.00	450,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	79,500.00	133,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	49,400.00	192,925.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	67,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,045,000.00	346,500.00
210807	Газрын төлбөр	81,382.00	62,632.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	700,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,733,379.00	5,599,785.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,733,379.00	5,599,785.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,530,873.67	101,150,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,679,000.00	101,150,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	52,200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,679,000.00	48,950,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,815,873.67	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,815,873.67	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,036,000.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	19,219,810.00	65,778,540.39
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	19,219,810.00	57,868,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,219,810.00	57,868,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	19,219,810.00	57,868,000.00
222001	Тоног төхөөрөмж	19,219,810.00	57,868,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-19,219,810.00	-57,868,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	7,910,540.39
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	7,910,540.39

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00	00.00
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	743,295,181.25	464,231,287.63	414,118,843.15	00.00	1,621,645,312.03
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	743,295,181.25	464,231,287.63	414,118,843.15	00.00	1,621,645,312.03
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	743,295,181.25	464,231,287.63	414,118,843.15	00.00	1,621,645,312.03
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00

D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	391,068,973.35	00.00	391,068,973.35
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	743,295,181.25	464,231,287.63	805,187,816.50	00.00	2,012,714,285.38

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	911,767,700.00	787,698,915.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	911,767,700.00	787,698,915.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	910,987,700.00	786,998,915.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	552,710,900.00	547,880,232.00
210101	Үндсэн цалин	333,160,500.00	331,908,168.00
210102	Нэмэгдэл	169,743,100.00	166,569,858.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,828,000.00	9,432,000.00
210104	Урамшуулал	39,979,300.00	39,970,206.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,616,000.00	70,536,693.00
210201	Тэтгэврийн даатгал	52,507,500.00	48,740,568.44
210202	Тэтгэмжийн даатгал	5,527,100.00	5,581,115.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,421,700.00	4,473,584.49
210204	Ажилгүйдлийн даатгал	1,105,500.00	1,104,577.16
210205	Эрүүл мэндийн даатгал	11,054,200.00	10,636,847.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	161,468,600.00	78,685,249.00
210301	Гэрэл, цахилгаан	20,272,200.00	10,702,282.00
210302	Түлш, халаалт	133,592,000.00	64,181,367.00
210303	Цэвэр, бохир ус	7,604,400.00	3,801,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,351,100.00	24,188,415.50
210401	Бичиг хэрэг	2,000,000.00	1,736,800.00
210402	Тээвэр, шатахуун	17,251,100.00	17,251,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.00	1,781,417.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,100,000.00	1,419,400.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00	1,999,798.00
2105	Нормативт зардал	56,806,200.00	45,041,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	42,356,200.00	34,856,200.00
210502	Хоол, хүнс	10,750,000.00	8,625,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,700,000.00	1,560,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,300,000.00	4,745,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,000,000.00	2,445,000.00
210604	Урсгал засвар	2,300,000.00	2,300,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,950,000.00	362,000.00
210702	Дотоод албан томилолт	1,950,000.00	362,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,441,400.00	10,090,341.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,758,400.00	8,946,359.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	900,000.00	450,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	158,000.00	133,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	83,900.00	83,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	67,000.00	67,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,350,000.00	346,500.00
210807	Газрын төлбөр	95,100.00	62,632.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	29,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11343500.00	5469785.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,343,500.00	5,469,785.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	780000.00	700000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	780,000.00	700,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	780,000.00	700,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	831,375,300.00	792,749,944.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	680,275,100.00	681,884,400.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	680,275,100.00	681,884,400.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	84,726,200.00	82,433,100.00
132001	Орон нутгийн төсвөөс	84,726,200.00	82,433,100.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	66,374,000.00	28,432,444.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	66,374,000.00	27,876,294.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	00.00	556,150.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	3,343,877.50
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	39.00	39.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	27.00	27.00
620003	Үйлчлэх ажилтан	11.00	11.00

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	489811305.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	104,638,779.11
210102	Нэмэгдэл	98,050,291.11
210104	Урамшуулал	6,588,488.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,322,425.00
210201	Тэтгэврийн даатгал	14,659,819.08
210202	Тэтгэмжийн даатгал	2,988,851.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	713,000.98
210204	Ажилгүйдлийн даатгал	178,250.50
210205	Эрүүл мэндийн даатгал	1,782,502.96
2104	Хангамж, бараа материалын зардал	7,230,428.00
210402	Тээвэр, шатахуун	4,430,428.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,800,000.00
2105	Нормативт зардал	189,696,548.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	165,967,048.00
210502	Хоол, хүнс	23,729,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	66,274,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	55,423,000.00
210604	Урсгал засвар	10,851,100.00
2107	Томилолт, зочны зардал	960,000.00
210702	Дотоод албан томилолт	960,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	109,025.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	109,025.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	130000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	130,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	100450000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	100,450,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	52,200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	48,250,000.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	00.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	00.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00
220001	Барилга байгууламж	00.00
221001	Их засвар	00.00
222001	Тоног төхөөрөмж	00.00
223001	Бусад хөрөнгө	00.00

224001	Стратегийн нөөц хөрөнгө	00.00
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00
2260	Гадаад эх үүсвэрээр	00.00
226001	Гадаад эх үүсвэрээр	00.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	00.00
230001	Эргэж төлөгдөх зээл	00.00
231001	Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих зээл	00.00
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	00.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	00.00
131103	ЗГНХ,ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00
131106	Төсвийн урамшуулал	00.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хутаг-Өндөр сумын ЭМТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлан, бүртгэлд гарсан алдаа зөрчилтэй, холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитын газрын ахлах аудитор П.Мөнхтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Хутаг-Өндөр сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хутаг-Өндөр сумын ЭМТ нь 2021 онд 5 зорилтын хүрээнд 24 ажил хийхээр төлөвлөж хөтөлбөрийн хэрэгжилт 95 хувьтай гарсан байна. Үүнд: Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр дотоод хяналтын нэгж тогтмол хуралдаж анхан шатны маягт хөтлөлт, эмнэлгийн цэвэрлэгээ халдваргүйжүүлэлтэд, тусгаарлах өрөөний бэлэн байдал, дархлаажуулалт гэсэн чиглэлээр хяналт шалгалтыг хийж ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар болон дотоод аудитын нэгжгүй болно. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хутаг-Өндөр сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт хөрөнгийн 1617.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 32.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 25.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад шинэчлэн тогтоогоогүй болно.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хутаг-Өндөр сумын ЭМТ нь 2021 оны санхүүгийн тайлангийн тодруулгыг Сангийн сайдын 388 дугаар журмын 3-р хавсралтын дагуу бэлтгэж тайлагнасан байна. Үүнд: Санхүү байдлын, Үр дүнгийн, Мөнгөн гүйлгээний, Өмчийн өөрчлөлтийн тайлангууд, санхүүгийн тодруулга тайлангуудын өөрчлөлт, нягтлан бодох бүртгэлийн зарчмыг баримтлан, НБББ, санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүнгийн талаар болзошгүй өр төлбөр, авлагыг зэргийг тодруулж тайлагнасан болно.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Хутаг-Өндөр сумын ЭМТ нь 2021 онд улсын төсвөөс 680.3, орон нутгийн төсвөөс 84.7, ЭМДС-гаас 66.4 сая төгрөг буюу нийт 831.4 сая төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөсөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тус сумын ЭМТ нь 2021 он улсын төсвөөс 681.9, орон нутгийн төсвөөс 82.4, ЭМДСангаас 28.4, нэмэлт дансаар 494.4 сая төгрөгийн буюу нийт 1287.1 сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 1279.1 сая төгрөгийг зарцуулж 0.1 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж мөнгөн гүйлгээний тайлангаар 7.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнажээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хутаг-Өндөр сумын ЭМТ нь 2021 онд нэмэлт дансаар нийт 489.8 сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр бүрэн зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Хутаг-Өндөр сумын ЭМТ нь 2021 онд ковид буюу цар тахалтай холбогдуулаад ЭМС-ийн 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А/496, 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А/585 тоот тушаалуудыг үндэслэн мөнгөн тэтгэмжинд 41.0, ковидын урамшуулал, нэмэгдэл цалингийн зардалд 264.6 сая төгрөгийг тус тус олгожээ.

Хандив тусламжаар ЭМЯ болон ЭМГ-аас 67.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 436.5 сая төгрөгийн бараа материалын орлого авч бүрэн тайлагнажээ.

Өөрийн хөрөнгөөр 57.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж бэлтгэсэн байна.

Жилийн эцэст 2124.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 160.4 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Тухайн онд 239.3 сая төгрөгийн авлага, 12.9 сая төгрөгийн өглөг тус тус нэмэгдсэн нь ЭМДС-гаас авах санхүүжилтийг авлага нэмэгдсэнтэй холбон үзэж байна.

Санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй 58.5 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулга хийх албан тоот хүсэлтийн дагуу санхүүгийн тайланд залруулга хийж баталгаажууллаа.

3.8 Аудитын гол асуудал

Тус сумын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулж ажиллахдаа аудитын төлөвлөлтийн үе шатанд сонгосон нийт 13 эрсдэлийн хүрээнд горим сорилыг хэрэгжүүлэн ажиллалаа.

Хэрэгжүүлсэн горим сорилоор ковидын 14.7 сая төгрөгийн мөнгөн тэтгэмж, урамшуулалыг давхардуулж олгосон, 0.3 сая төгрөгийн цалинг илүү шилжүүлсэн, ажилчдад үр дүн, ажлын үзүүлэлтээр дүгнэхдээ ижил түвшингээр дүгнэсэн, албан томилолтоор ажилласан ажлын удирдамж, тайлан байхгүй, шатахуун зарцуулалтын дарыгн цохолт дутуу, алсын дуудлага, жолоочийн тооцооны замын хуудас зөрүүтэй бүртгэгдсэн, анхан шатны баримтын бүрдэлд дутуу, няравын тайлагнасан эмийн тайлангийн орлого, зарлагын дүнг бараа материалын тодруулга тайлангийн дүнтэй тулгахад орлогыг 5.1, зарлагыг 4.3 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан зэрэг зөрчлүүд илэрч байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээлэх мэдээллийг бүрэн мэдээлсэн боловч 20 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн дагуу шилэн дансны мэдээллийг бүрэн мэдээлж ажилласан ч хугацаа хоцроож мэдээлсэн нь холбогдох шалгуурт нийцэхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар 3 зөвлөмж өгч ажилласнаас зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 82 тоот албан бичгээр хүргүүлжээ.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус сумын ЭМТ нь 2022 оноос эхлэн гүйцэтгэлээрээ санхүүжиж байгаатай холбогдуулан өөрийн үйл ажиллагааны орлого болон гүйцэтгэлийг дараагийн аудитаар шалгах асуудалд оруулах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 80.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 15.5 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт, 6.0 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 0.6 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгч, 58.5 сая төгрөгийн алдааг залруулж ажиллалаа.

4.1 Залруулсан алдаа

Мөнгөн гүйлгээний тайланд 57.8 сая төгрөгийн хөрөнгийн зарлагын дансыг, бараа материалын тодруулга тайлангийн 0.6 сая төгрөгийн материалын зарлагын дансыг тус тус буруу илэрхийлсэн зөрчлийг НББ-ийн тухай 15 дугаар зүйлд заасны дагуу залруулга хийж баталгаажуулан ажиллалаа.

4.2 Төлбөрийн акт

1. Тус сумын ЭМТ-ийн 2021 оны цалингийн зарцуулалтыг түүвэрлэн шалгахад 295859 төгрөгийн цалин илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, НББ-ийн тухай хуулийн 13.1. “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоов.

2. Тус сумын ЭМТ-ийн 2021 оны ковид цар тахалтай холбогдуулан олгосон тэтгэмж, урамшуулалыг түүвэрлэн шалгахад 14750000 төгрөгийн тэтгэмж давхардуулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, НББ-ийн тухай хуулийн 13.1. “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, ЭМС-ын 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А/496, 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А/585 тоот тушаалын заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоов.

3. Тус сумын ЭМТ-ийн 2021 оны шатахуун зарцуулалтыг түүвэрлэн шалгахад анхан шатны баримтын бүрдэл дутуу, даргын цохолтгүй, алсын дуудлага болон жолоочийн тооцооны замын хуудсны бүртгэл зөрүүтэй баримтаар 494420 төгрөгийн шатахуун зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

1. Тус сумын ЭМТ-ийн 2021 оны томилолтын зардлыг түүвэрлэн шалгахад 960000 төгрөгийн томилолтын удирдамж, ажлын тайлан байхгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу байгаа нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага бичлээ.

2. Тус сумын ЭМТ-ийн 2021 оны няравын тайлагнасан эмийн орлого, зарлагын дүнг бараа материалын тодруулга тайлангийн дүнтэй тулгахад орлогыг 5087200, зарлагыг 4337500 төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, эмийн зарцуулалтын тайланг үнэн зөв тайлагнаагүй нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага бичлээ.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үр дүнгийн урамшуулалтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Ажилчдын үр дүнг дүгнэхдээ ижил түвшингээр дүгнэж урамшуулал олгосон байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Ажилчдын үр дүнг дүгнэхдээ шалгуур үзүүлэлтээр дүгнэж, үнэлгээг өгч урамшуулал олгох хувийг үнэн зөв тогтоож ажиллах.

2. Түлш халаалтын зардалтай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Түлш халаалтын зардлаас гэрэл цахилгааны 0.6 сая төгрөгийг шилжүүлэн зарцуулсан.

2.2 Өгсөн зөвлөмж

Батлагдсан төсвийг эдийн засгийн ангилалаар нь шилжүүлэн зарцуулж, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал, ашиглах заавар”-ыг мөрдлөгөө болгож ажиллах.

3. Шилэн данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Шилэн дансанд мэдээлсэн мэдээллүүдээс 20 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.2 Өгсөн зөвлөмж

Шилэн дансны тухай хуулийн дагуу цаг хугацаанд нь мэдээлж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 02 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая/төгрөгөөр/

д/ д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хутаг-Өндөр сумын ЭМТ	10	80.6	2	58.5	3	15.5	2	6.0	3	0.6

